



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2014 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 676

Номгон

Мотоциклийн хөдөлгөөнийг түр хугацаагаар  
хориглох тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.6.1, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зорчих хэсгийн гадаргуу цасаар хучигдан халтиргаа гулгаа үүсч авто замын нөхцөл байдал хүндэрсэн үед мотоциклоор замын хөдөлгөөнд оролцогчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдлийг багасгах зорилгоор Баянхонгор аймгийн хэмжээнд мотоцикльтойгоор замын хөдөлгөөнд оролцохыг 2014 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2015 оны 03 дугаар сарын 20-ныг хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж илэрсэн зөрчлийг арилгуулах, иргэдэд хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт болон Цагдаагийн газрын дарга /Цагдаагийн хурандаа Б.Оюутболд/-д даалгасугай.

3.Захирамжид тусгагдсан арга хэмжээний үр дүн, явц байдлын талаар болон хойшид авах арга хэмжээний саналыг танилцуулж байхыг Цагдаагийн газар /Цагдаагийн хурандаа Б.Оюутболд/, Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тасаг /Цагдаагийн дэд хурандаа Н.Мөнх-Эрдэнэ/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЖАРГАЛСАЙХАН